

6th Story

Саа өвчтнийг эдгээсэвч нь

Through the Roof

Саа өвчтөнийг эдгээсэн нь!

– 6th Story –



Өгүүлэгч

Есүс олон газраар явж заасан бөгөөд явсан газар бүрт хүмүүс сургаалыг нь сонсохоор цуглардаг байлаа. Нэг удаа Есүс жижигхэн гэрт хүмүүст сургаал зааж байв. Энэ мэдээ тосгон даяар тархаж бүр ч илүү их хүн цугларав. Жижиг гэрт олон хүн цуглармагц бөгс эргэх зайгүй бэрх болжээ.

Найз 1

Пөөх ... орохын аргагүй болжээ? Ямар олон хүн байна аа. Яадаг юм билээ?

Найз 2

Гэхдээ бид Есүсийг харах гэж ирсэн шүү дээ.

Саа өвчтөн

Найзууд аа, би Есүсийг сайн мэднэ. Түүний талаар маш их сонсож байсан. Есүс л намайг эдгээж чадна.

Найз 2

Бид ч бас мэднэ ээ... гэхдээ пиг хүнтэй байна.

Найз 3

тэхх ... бид яавал орж чадах вэ?

Найз 2

алив харъя... хаалгыг нь бүр хүмүүс таглачихаж?

Найз 1

Цонх нь ч гэсэн таглаатай? Мэдэх юм алга. Ер нь л хэцүүхэн шүү?

Саа өвчтөн

Дээвэр~!!

Найзууд

Юу?

Саа өвчтөн

Дээврийг хуулаад намайг буулгаж өгч чадах уу? Айл бүрт дээврийн хаалт байдаг шүү дээ. Бид тийшээ авчирч гарч чадвал та нар намайг түүгээр буулгаж өгч чадах уу?

Найз 3

тэгье тэгье, маш аятайхан санаа байна?

Найз 2

тэгье. Сайхан санаа байна. Асуудал нь бид тэр дээшээ яаж авирч гарах вэ гэдэг л байна.

Саа өвчтөн

Би гэрийн ард дээвэр рүү авирч гарах шат харсан юм шиг байна.

Найз 1

за тэгвэл хийж үзье. Хурдал хурдал

Найз 2

чи тарган биш байгаа нь үнэхээр ивээл шүү. Чи хөнгөн учраас хамаагүй амар байж магад?

Өгүүлэгч

Хэсэг хүчин чармайлт гаргасаны дараа, дөрвөн найз өвдсөн найзыгаа дээвэр рүү дагуулж явлаа. Есүс тэр хооронд хүмүүст зааж, эдгээж байлаа.

Саа өвчтөн

найзууд аа, намайг доош буулгаач. Болгоомжтой ~~

Найзууд

за ... бүх юм сайхан болно. Сайн бариарай за юу?



- Өгүүлэгч** Найзууд өвдсөн найзыгаа тооноор оруулах үед, Есүс хийж байсан зүйлээ зогсоов. Тэгээд бууж буй хүнийг ширтэв. Өвдсөн найз нь хүмүүсийн дунд, яг Есүсийн урд буулаа. Тэнд байсан хүмүүс бүгд ихэд гайхав. Харин Есүс инээмсэглэсэн.
- Есүс** Сайн уу~!!
- Саа өвчтөн** Сай, сайн байна уу багшаа!
- Есүс** Бүү санаа зов. Чиний бүх гэм нүгэл бүгд уучлагдсан.
- Өгүүлэгч** Есүс энэ үгийг айлдмагц тэнд харж байсан фарисайчууд тэгэж хэлснээс нь болж уурлаж эхлэв.
- Фарисай** Энэ хүн одоо Бурханыг доромжилж байгаан биш үү? Хэн болоод хэнийг уучилж байгаа юм бол? Өөрийгөө Бурхан гэж бодсон юм байх даа?
- Өгүүлэгч** Есүс энэ хуулийг заадаг фарисайчууд юунаас болж ийм үг хэлснийг мэдэж байлаа. Тиймээс тэдэнд ингэж айлдсан.
- Есүс** Юунд та нар зүрхэндээ ийн эргэцүүлнэ вэ? “Нүгэл чинь уучлагдсан” гэж хэлэх эсвэл “Босоод алх” гэж хэлэхийн аль нь амархан бэ? Харин Бурхан нүглүүдийг уучлах эрх мэдлийг Надад өгсөн гэдгийг мэдэгтүн.
(Өвдсөн найз руу харан) Би чамд хэлье. Бос~!! дэвсгэрээ аваад гэртээ харь ~!
- Өгүүлэгч** Яг тэр үед, тэр даруй саа өвчнөөр хөдөлж ч чадахгүй байсан найз нь гайхамшиг мэт боссон. Алхаж эхэлсэн.
- Саа өвчтөн** Өө Бурхан минь~!!, Эзэн минь~~ баярлалаа. Талархлаа~~, Эзэн минь Та л намайг эдгээнэ гэдгийг мэдэж байсан. Бурхан мандтугай~~
- Хүмүүс** <гайхацгаан> Пөөх ~ хөөх ~~ Халлелүяа~~ гайхалтай~~
- Өгүүлэгч** Өвдсөн найз нь Бурханыг магтан алдаршуулсаар явлаа. Мэдээж өөрийнхөө хоёр хөлөөр найзуудтайгаа хамт алхаад явсан. Олон хүн саа өвчтөнийг дахин алхуулсан Есүсийг хараад гайхан шагширч Тэр жинхэнэ ямар Нэгэн болохыг сонирхсон боловч, зарим нь Есүст эргэлзэж ч байсан юм.